

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ IV УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ

/Зам, тээврийн хөгжлийн яам/

2019.12.20

д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	2019 онд хүрэх түвшин, үр дүн Шалгуур үзүүлэлт	2019 онд зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр /сая төг/	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь	УИХ тогоолын хэрэгжилт хувь
1	2	3	4	5	6	7	
1	<b>Бодит салбарын өсөлтийг дэмжих, зам, тээврийн бодлого хэрэгжүүлж, логиستيкийн сүлжээг өргөжүүлнэ.</b>						
1	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.107 дахь заалт	7.1. Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөтгөх	Ашиглалта д оруулах хатуу хучилттай авто замын урт, км 500  Ашиглалта д оруулах төмөр бетон гүүрийн урт, метр130	41'626.2	1. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын 2.29 км хайрган хучилттай авто замыг улсын комиссын 10/01/19 дүгээр дүгнэлтээр; 2. "Эрдэнэс таван толгой" ХХК-ийн уурхайгаас Ухаа худаг-Гашуунсухайт чиглэлийн авто замтай холбох 8.2 км авто замыг улсын комиссын 10/02/19 дүгээр дүгнэлтээр; 3. Төв аймаг Зуунмод сумын 26-р багт баригдсан 0.4 км хатуу хучилттай авто замыг улсын комиссын 10/03/19 дүгээр дүгнэлтээр; 4. Булган-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 22 км авто замыг улсын комиссын 10/04/19 дүгээр дүгнэлтээр; 5. Аглаг бүтээлийн хийд чиглэлийн 6.2 км авто замыг улсын комиссын 10/05/19 дүгээр дүгнэлтээр; 6. Улаанбаатар-Хөшигийн хөндий чиглэлийн 32.226 км авто замыг улсын комиссын 10/07/19 дүгээр дүгнэлтээр; 7. Донойн нисэх буудлын хөөрч, буух хатуу хучилттай зурвас, явгалах зам, үерийн хамгаалалтын далангын ажлыг улсын комиссын 10/09/19 дүгээр дүгнэлтээр; 8. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто замыг улсын комиссын 10/10/19 дүгээр дүгнэлтээр; 9. Баянхонгор-Байдрагын гүүр чиглэлийн 129.4 км авто замыг улсын комиссын 10/11/19 дүгээр дүгнэлтээр; 10. Баянзүрх дүүрэг 16 хороо Хорооллын доторх 3 км авто замын засварын ажлыг улсын комиссын 10/14/19 дүгээр дүгнэлтээр; 11. Тосонцэнгэлийн 4 замын уулзвар Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замыг улсын комиссын 10/15/19 дүгээр дүгнэлтээр;	100%	

					<p>12. Гэр хорооллын авто замын засвар, шинэчлэлт 1 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20-р хороо/ авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг улсын комиссын 10/16/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>13. “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын төсөл”-ийн концесс эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр хэрэгжиж буй 126.7 км хатуу хучилттай авто замын 30 км авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/17/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>14. “Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн барих-шилжүүлэх (BT) концессын гэрээгээр хэрэгжиж буй авто замын үлдсэн хэсэг болох 52.2 км авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/18/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>15. Чингис хот-Бэрх чиглэлийн аялал хатуу хучилттай авто замын эхлэл /20 км/ авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/19/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>16. “Морингын давааны хатуу хучилттай авто зам 1.2 км /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10-р хороо/” авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/20/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>17. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэрийг Сайншанд хоттой холбох 17.5 км хүнд даацын хатуу хучилттай авто замыг улсын комиссын 10/21/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>18. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэр чиглэлийн дагнасан хэрэглээний салбар төмөр зам Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн АН-3 авто замтай огтлолцож буй хэсэгт баригдсан 3.686 км авто замын барилгын ажлыг улсын комиссын 10/22/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>19. “Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутагт Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх MON-2710/0240 төсөл”-ийн хүрээнд баригдсан логистикийн төвийг Замын-Үүд сумтай холбох 4.347 км авто замын барилгын ажил улсын комиссын 10/23/19 дүгээр дүгнэлтээр;</p> <p>20. Ховд-Өлгий чиглэлийн 60 км авто замын барилгын ажлыг 10/24/19 дүгээр дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулсан.</p> <p>Нийт <b>672.359 км</b> хатуу хучилттай авто замыг ашиглалтад хүлээн авсан.</p>	
--	--	--	--	--	--	--

					<p><b>АЗБХЗГ:</b> Тайлант хугацаанд Ховд-Өлгий чиглэлийн 60 км авто замын барилгын ажлын гүйцэтгэл тайлант хугацаанд гүйцэтгэл 100%-тай. Улсын комисс 2019.11.16-ны өдөр хүлээн авч, <b>10/24/19</b> дүгээр дүгнэлтээр ашиглалтад оруулсан. Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад 2016 онд гарсан шүүхийн шийдвэрийн улмаас АХБ-ны хөрөнгө оруулалтыг ашиглах боломжгүй болоод байсан ба тус багц хэсгийг санхүүжүүлэх хүсэлтийг дахин 2019.03.28-ны өдөр АХБ-нд тавьсан. АХБ-аас тус багц хэсгийн гүйцэтгэгчийн тендерийг дахин зарлах зөвшөөрлийг 2019.07.30-ны өдөр ирүүлсэн. Тендерийн баримт бичгийн төсөлд 2019.09.11-ний өдөр АХБ-аас зөвшөөрөл авч, тендерийг 2019.09.12-ны өдөр зарласан. Тендерийг 2019.10.25-нд нээсэн ба үнэлгээний тайланг 2019.11.29-ний өдөр АХБ-нд хүргүүлсэн. Энэ ондоо багтаж гэрээ байгуулна. <b>Нийт гүйцэтгэл 82%-тай.</b></p>	70%	
		7.1.1. Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 85 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 85	26,906.9			
		7.1.2. Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	5,555.9	<p><b>АЗБХЗГ:</b> Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум чиглэлийн 20.3 км авто замын барилгын ажлын гэрээг гүйцэтгэгч байгуулагатай 2018.11.12-ны өдөр байгуулсан. Зам барилгын ажил 2019.04.01-ний өдөр эхэлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл тайлант хугацаанд <b>90.4%-тай</b> байна. Гэрээгээр 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулна. Энэ оны зам барилгын ажлын график төлөвлөгөө <b>100%</b> биелэсэн.</p>	100%	
		7.1.3. Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн 32.2 км хурдны авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	/Барилга+ зөвлөх/ 90,332.2	<p><b>АЗБХЗГ:</b> Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.226 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Чайна Тиэсэжү Сивил Инжеренг Групп” ХХК шалгарч 2015.09.18-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр нийт 140,335,893.00 ам.долларын барилгын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан. Хяналтын зөвлөхөөр БНХАУ-ын “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” компани шалгарч 2016.05.18-ны өдөр 7,207,921.00 ам.долларын зөвлөхийн</p>	100%	

					<p>үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж байна. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 60 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай.</p> <p>Улсын комисс 2019.07.03-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/07/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.</p>		
		7.1.4. Баянхонгор-Арвайхээр чиглэлийн авто замын огцом эргэлтийг өөрчлөх 4.4 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	1,677.0	<p><b>АЗБХЗГ:</b> “Их богд зам” ХХК 2019 оны барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу далангийн дүүргэлт, ухмалын ажил, суурийн доод үе, буталсан чулуун суурь, хучилт хийгдсэн. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай.</p> <p>Улсын комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн.</p>	100%	
		7.1.5. Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн авто замын төгсгөлийн 22 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	3,000.0 сая төгрөг	<p><b>АЗБХЗГ:</b> “Эйч Кэй Би” ХХК барилгын ажлыг гүйцэтгэсэн. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай.</p> <p>Улсын комисс 2019.07.06-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/04/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.</p>	100%	
		7.1.6. Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100		<p><b>АЗБХЗГ:</b> “Монгол ЛЗ” ХХК барилгын ажлыг гүйцэтгэсэн. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/01/2018 дугаартай зөвшөөрлийг 2018.01.05-ны өдөр олгосон. Зам барилгын ажлыг 2019.04.25-ны өдөр эхлүүлсэн. Зам барилгын талбайд нийт 452 /монгол-99, хятад-353/ ИТА, 155 ширхэг тоног төхөөрөмж, машин механизмтай ажилласан. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай.</p> <p>Улсын комисс 2019.11.11-ний өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан Комиссын <b>10/15/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.</p>	100%	
		7.1.7. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100		<p><b>АЗБХЗГ:</b> “Шинжиан шин-фа” ХХК барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/18/2017 дугаартай зөвшөөрлийг 2017.12.26-ны өдөр олгосон. Үндэсний хөгжлийн газраас өгсөн тайлбараар концессын гэрээний дагуу Зөвлөхийн зардлыг холбогдох дансанд</p>	-	

			замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам			байршуулаагүй тул Зөвлөх барилгын ажлын талбайд гараагүй байна. Концесс эзэмшигчээс далан, ухмал, хиймэл байгууламжийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ойролцоогоор нийт ажлын <b>20%-ийг хийж гүйцэтгэсэн</b> талаар Үндэсний хөгжлийн газарт мэдээ өгсөн боловч эдгээр ажил нь Зөвлөхөөр баталгаажуулаагүй байна. Эрх бүхий байгууллагаас шалгалт хийж байгаа бөгөөд 2019 онд зам барилгын ажил хийгдээгүйг тогтоосон ба зам барилгын ажлыг эхлүүлэх талаар тодорхой тов гараагүй.		
			7.1.8. Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100		<b>АЗБХЗГ:</b> Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Хөрөнгө оруулалтын газраас /хуучнаар/ “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-тай 2015.08.15-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигч “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК нь гүйцэтгэгч “Монроуд” ХХК-тай гэрээгээ сунгасан бөгөөд 2018.05.15-ны өдрөөс зам барилгын ажлыг эхлүүлсэн ба 12.9 хувийг хийж гүйцэтгэсэн. Засгийн газрын 2019.04.10-ны өдрийн хуралдаанаар уг концессын эзэмшигчийн эрх, үүргийг “Макс рөүд” ХХК-д шилжүүлэхээр шийдвэрлэсэн. 2019.05.09-ний өдөр “Макс рөүд” ХХК-тай гэрээний хэлцэл хийж, концессын гэрээ байгуулсан бөгөөд тус компани зам барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр, “Аварга зам” ХХК Зөвлөхөөр үргэлжлүүлэн ажиллаж байна. 2019 онд газар шорооны ажлын 62%, суурийн ажлын 30%, хойлойн ажлын 35%, гүүрийн ажлын 40%, хучилтын ажлын 24%-ийг, нийт ажлын 45%-ийг хийж гүйцэтгэн, эхний 30 км замыг ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/17/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.	70%	
			7.1.9. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	/Барилга+ зөвлөх/ 15,358.3	<b>АЗБХЗГ:</b> Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт 42,198,856.39 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан.	100%	

					Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 35 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.05.25-ны өдөр эхлүүлсэн. Нийт ажлын явц 100%-тай. Улсын комисс 2019.08.08-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/10/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.		
			Ашиглалта д оруулах төмөр бетон гүүрийн урт, метр130		1. Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Согоогын голын 18.7 урт метр төмөрбетон гүүрийг улсын комиссын 10/01/19 дүгээр дүгнэлтээр; 2. Төв аймаг Зуунмод сумын 26-р багт баригдсан 16.2 урт метр төмөрбетон гүүрийг улсын комиссын 10/03/19 дүгээр дүгнэлтээр; 3. Намирын голын 48.75 урт метр төмөрбетон гүүрийг улсын комиссын 10/06/19 дүгээр дүгнэлтээр; 4. Хэрлэнгийн доод 264 урт метр төмөрбетон гүүрийн их засвар, шинэчлэлтийн ажлыг улсын комиссын 10/08/19 дүгээр дүгнэлтээр; 5. Ширээгийн голын 90.9 урт метр төмөрбетон гүүрийг улсын комиссын 10/12/19 дүгээр дүгнэлтээр; 6. Баянгол дүүрэг Гэр бүл ёслолын ордны авто зогсоол, явган гүүрийг улсын комиссын 10/13/19 дүгээр дүгнэлтээр;  Нийт <b>438.55 урт/метр</b> гүүрийг ашиглалтад хүлээн авсан		100%
		7.1.10. Согоогийн голын 18,7 у/м төмөрбетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус/	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	614.7 сая төгрөг	<b>АЗБХЗГ:</b> Тус гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Жол” ХХК ажилласан. 2019 оны барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг батлуулж, барилгын ажлыг 2019.04.01-нээс эхэлсэн. Нийт ажлын явц 100%-тай. Улсын комисс 2019.06.012-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/01/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.	100%	
		7.1.11. Бооржийн голын 30,68 у/м төмөрбетон гүүр /Ховд, Мөст/	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	376.8 сая төгрөг	<b>АЗБХЗГ:</b> “Эйч Кэй Би Интернейшнл холдинг” ХХК барилгын ажлыг гүйцэтгэсэн. Нийт ажлын явц 100%-тай. Улсын комисс 2018.11.02-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>07/09/18 дугаар дүгнэлтээр</b> баталгаажуулсан.	100%	

						Үлдэгдэл санхүүжилт 2019 оны төсөвт тусгагдаж, бүрэн санхүүжсэн.		
			7.1.12. Намирын голын 48 у/м төмөрбетон гүүр /Увс, Өмнөговь/	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	2,079.6 сая төгрөг	<b>АЗБХЗГ:</b> “Тэргүүн саруул зам” ХХК барилгын ажлыг гүйцэтгэсэн. Нийт ажлын явц 100%-тай байна. Улсын комисс 2019.08.22-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/06/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.	100%	
			7.1.13. Ширээгийн голын 90.9 у/м төмөрбетон гүүр /Завхан, Цагаанхайрхан/	Барилгын ажлын гүйцэтгэл хувиар 100	972.3 сая төгрөг	<b>АЗБХЗГ:</b> “ЗЗБ”ХХК 2019 оны батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилгын ажлыг гүйцэтгэсэн. Нийт ажлын явц 100%-тай байна. Улсын комисс 2019.11.08-ны өдөр хүлээн авч, ашиглалтад оруулсан. Комиссын <b>10/12/19 дүгээр дүгнэлтээр</b> баталгаажуулсан.	100%	
2	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.121 дэх заалт	7.2. Авто замын засвар арчлалтын хугацааг уртасгах, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	7.2.1. Улсын чанартай 15231 км авто зам, замын байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах	Засварын ажлын гүйцэтгэл хувиар 100	29,968.8 сая төгрөг	<b>АЗБХЗГ:</b> Улсын төсөвт улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд 30.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд 2019 оны төлөвлөгөөг замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан гаргаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 288 дугаар тушаалаар батлуулж, зам хариуцагч төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 12 нийт 32 компанитай гэрээ байгуулан, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 30%-ийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон. Өвлийн арчлалтын 47 цэгт “Шуурхай ажлын хэсэг” гарч ажилласан. Олон улсын болон улсын чанартай 14918.7 км авто зам, замын байгууламжийн өдөр тутмын байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Энэ онд хийгдэх замын засвар арчлалтын ажил 2019.12.02-ны өдрийн байдлаар 92%-тай хэрэгжиж байна.	100%	100%
			7.2.2. Улсын чанартай авто замд байрлах 207 у/м төмөр бетон гүүрийн их засвар, шинэчлэлт	Засварын ажлын гүйцэтгэл хувиар 100		<b>АЗБХЗГ:</b> Дорнод аймгийн Хэрлэнгийн доод 264 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлыг гүйцэтгэхээр “ЗМЗ” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай. Улсын комисс 2019.09.23-ны өдөр хүлээн авч, <b>10/08/19 дүгээр дүгнэлтээр</b> ашиглалтад оруулсан.	100%	

					<p>Хэнтий аймгийн Дадал сумын 238.9 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлыг гүйцэтгэхээр "Гангүүр" ХХК-тай гэрээ байгуулсан. Нийт ажлын <b>гүйцэтгэл 65%-тай</b>. Гэрээ ёсоор 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад оруулна.</p> <p>Увс аймгийн Улаангом сумын Гашууны голын 72 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлын гүйцэтгэгчээр "Тэргүүн саруул зам" ХХК шалгарч гэрээ байгуулсан. <b>Нийт ажлын гүйцэтгэл 45%-тай</b>. Гэрээ ёсоор 2020 оны 8 дугаар сарын 1-ний өдөр ашиглалтад оруулна.</p>		
		7.2.3. "Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийг хэрэгжүүлэх	Ажлын гүйцэтгэл хувиар 10	58,840.0 сая төг	<p><b>АЗБХЗГ:</b> АХБ-ны зээлийн хөрөнгөөр хэрэгжих "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замд өргөтгөл, шинэчлэлт хийх /2019-2020 онд/</li> <li>2. Дархан-Улаанбаатар чиглэлийн авто зам аюулгүй байдлыг сайжруулах засвар хийх /2020-2021 онд/</li> <li>3. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замд их засвар хийх /2020-2022 онд/</li> <li>4. Хэнтий-Норвилон-Дадал чиглэлийн 273 км авто замд суурь судалгааны ажил хийх /2020 онд/</li> <li>5. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих /2019-2022 онд/ зэрэг ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</li> </ol> <p>2019 онд төслийн хүрээнд дараах ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>■ Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын ажлын зураг төслийг 2019 оны 03 дугаар сард эцэслэн боловсруулж дуусгасан. Зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг 5 багц хэсгээр 2019.03.21-нд зарлаж, 2019.05.02-ны өдөр нээсэн. Шалгарсан гүйцэтгэгч компаниудтай 2019.06.12-14-ний өдрүүдэд байгуулсан. Зам барилгын ажлыг 2019.06.17-ны өдөр эхлүүлсэн. Тайлант хугацаанд нийт барилгын ажлыг гүйцэтгэл <b>33.2%-тай</b> байна.</li> </ul>	100%	100%



					<ul style="list-style-type: none"> <li>▪ Зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөхийн сонгон шалгаруулалтын ажлыг 2019.01.05 өдөр зохион байгуулж, шалгарсан зөвлөх компанитай 2019.06.05-ны өдөр байгуулан, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж байна.</li> <li>▪ Төслийн 2 дахь шатны МОН-3786 зээлийн хэлэлцээрийг 2019.03.13-14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2019.09.12-ны өдөр УИХ-аар соёрхон баталсан ба Зээлийн гэрээг МУ-ын ЗГ болон АХБ хооронд 2019.09.13-ны өдөр байгуулсан.</li> <li>▪ Дархан-Албанбулаг чиглэлийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн засвар арчлалтын ажлыг зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн.</li> </ul> <p>Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засвар ажлын зураг төслийг 2019.08 дугаар сард боловсруулж дууссан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж АХБ-аас зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. Энэ онд багтаж тендер зарлана.</p>		
3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.119 дэх заалт	7.3. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах, түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээ авах	7.3.1. Яармагийн 260 у/м шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах барилгын ажил	Барилгын ажлын явц, хувиар 100	<p><b>АЗБХЗГ, НЗДТГ:</b> Төслийн гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 20-р товчоо групп” корпораци төслийн зураг төсөв боловсруулах болон барилгын ажлыг гүйцэтгэнэ. Төслийн нийт өртөг 30.26 сая ам.доллар, хэрэгжүүлэх хугацаа 2016.10.01-2019.01.30.</p> <p>-Төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа 2019.01.31-ний өдрөөр дуусгавар болсон тул үлдэгдэл ажлыг гүйцэтгэх график төлөвлөгөөг гаргуулж, төслийн ажлыг дуусгах асуудлаар зөвшилцөж 2019.04.01-ний өдрөөс барилгын ажил эхлүүлсэн.</p> <p>Төслийн хүрээнд 4 эгнээ шинэ гүүр бүхий 250 у/м, 20.5 м өргөнтэй, 50 у/м нүхэн гарц, D-рампын шинэ гүүр нь 276 у/м, 8.5 м өргөнтэй, 2 эгнээ бүхий хуучин гүүр нь 250 у/м, 9 м өргөнтэй, 57 у/м тунелтэй, гэрэлтүүлэг, борооны ус зайлуулах шугам, инженерийн шугам сүлжээний ажлуудыг</p>	100%	100%

					тус тус хийхээр төлөвлөж гүүрийн барилгын ажлыг бүрэн дуусган улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хангагдаж байна. Нийт ажлын явц 100%.		
		7.3.2. Замын цагдаагийн газрын ойролцоох гарц барих	Замын газрын гүүрэн	Барилгын ажлын явц, хувиар 100	<p><b>АЗБХЗГ, НЗДТГ:</b> Төслийн гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 20-р товчоо групп” корпорацн төслийн зураг төсөв боловсруулах болон барилгын ажлыг гүйцэтгэнэ. Төслийн нийт өртөг 42.38 сая ам.доллар. Хэрэгжүүлэх хугацаа 2016.11.30-2019.09.30.</p> <p>Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн хүрээнд 477 у/м, 4 эгнээ, гүүрэн гарц, нарны замаас төмөр зам дээгүүр 276 у/м, 1 эгнээ, гүүрэн налуу зам, нарны зам руу буух 218,5 у/м, 1 эгнээ, нарны замаас гүүр рүү гарах 337 у/м зам, гүүр, 1 эгнээ, гүүрэн налуу зам, 2.5 м өргөнтэй явган хүний гүүр, гүүрийн 2 талын авто зам зэрэг ажлууд тус тус хийгдэнэ.</li> <li>Үндсэн гүүр, В рампын зам барилгын ажил, тэмдэг тэмдэглэгээ болон гэрэлтүүлгийн ажил хийгдэж авто замын хөдөлгөөнийг нээсэн.</li> <li>-L туслах 66 у/м гүүр /Дунд гол дээрх/-ийн ажлыг дуусган буцаж эргэх U-эргэлтийн хамт асфальтбетон хучилт хийж, түр замын замын хөдөлгөөнийг нээсэн.</li> </ul> <p>2019 оны эцсийн байдлаар төслийн барилгын ажлын А, С рамп, Олимпийн гудамжийг Нарны замтай холбосон үндсэн гүүрийн 2 талаар авто зам, U-эргэлтийн баруун хэсэгт Дунд гол дээгүүрх гүүрэн болон авто зам, үлдэгдэл гэрэлтүүлгийн ажил, явган хүний гүүр болон авто зам, инженерийн шугам сүлжээний ажлуудыг 2020 оны 09 сард багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Нийт ажлын явц 85%.</p>	70%	70%
		7.3.3. Баянзүрх дүүргийн болон Сонсголонгийн 289,4 у/м төмөр	321 у/м	Барилгын ажлын явц, хувиар 90	<p><b>АЗБХЗГ, НЗДТГ:</b> Төслийн гүйцэтгэгч “Бээжин Юни-Констракшн Групп”ХХК, туслан гүйцэтгэгч “Гангүүр”ХХК барилгын ажил гүйцэтгэнэ. Төслийн зөвлөх үйлчилгээний ажлыг мөн зээлийн хөрөнгөөр “Гуанжоу Ванан Констракшн Сүпервишн” компани ажиллаж байна. Төслийн</p>	100%	100%

			бетон гүүрийн барилгын ажил		<p>нийт өртөг 21.4 сая ам.доллар. Хэрэгжүүлэх хугацаа 22 сар.</p> <p>Гүүрийн барилгын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн. Төслийн хүрээнд Сонсголонгийн гүүрийг засварлаж, шинээр 289.4 у/м, 21.9 м өргөнтэй, 2 эгнээ төмөрбетон гүүрийг параллелаар шинээр барьж өргөтгөх ба Налайхын чиглэлийн шинэ замын дагуу Баянзүрхийн гүүрийн ойролцоо шинээр 281.2 у/м, 22.6 м өргөнтэй, 4 эгнээ, үргэлжилсэн хайрцган дам нуруу бүхий төмөрбетон гүүрийн барилга угсралтын ажил хийгдсэн. Сонсголонгийн гүүрийн барилгын ажлын гүйцэтгэл 100%-тай. Комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хангагдаж байна.</p> <p>Баянзүрхийн гүүрийн барилгын ажил дуусч авто замын зорчих хэсгийн хөдөлгөөнийг нээсэн бөгөөд үерийн хамгаалалтын далангийн ажил, нөхөн сэргээлт, явган хүний замын хавтан суурилуулах ажлуудыг 2020 оны 06 сард багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Баянзүрхийн гүүрийн барилгын ажлын гүйцэтгэл 93.55%-тай.</p>		
			7.3.4. Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл шинэчлэлт хийх;	Барилгын ажлын явц, хувиар 75	<p><b>АЗБХЗГ</b>, НЗДТГ: Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч Синохайдро Корпорейшн Лимитед компани Монголын үндэсний аж ахуйн нэгжүүд болох “Дардан говь” ХХК, “Тэгш плант” ХХК, “Гашууны гол” ХХК зэрэг нийт 3 туслан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.</p> <p>Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 300 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.</p> <p>Зам барилгын ажлыг 2019.04.20-ны өдрөөс эхлүүлж, 2019.11.04-ний өдөр 4 эгнээ авто замын зорчих хэсгийг дуусгаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээгээд байна.</p> <p>Замын хуучин цементбетон хучилтыг хуулж зөөх ажил 100%, ухмал 100%, далангийн дүүргэлт 100%, 38 цэгт баригдах ус зайлуулах хоолойн ажил 100%, 3 ш нүхэн гарц буюу түннелийн ажил 100%, Хөлийн голын төмөрбетон гүүрийн ажил 100%, үндсэн 20.9 км авто замын суурь асфальтбетон хучилтын ажил 100%-тай байна.</p>	100%	100%

					Үлдэгдэл ажлууд болох төмөр туузан хашлага, суурьшлийн бүсийн хэсгүүдийн 5.1 км явган хүний болон дугуйн зам, 5 цэгт явган хүний гүүрэн гарц, өнгө асфальтбетон хучилт буюу 4 см-ээр нэмж хучих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн 2020 оны 7 дугаар сард багтаан бүрэн ашиглалтад оруулна.		
		7.3.5. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн явц хувиар 30		<b>АТБХЗГ, НЗДТГ:</b> Үндэсний хөтөлбөр боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 100 дугаар тушаалаар байгуулав. Ажлын хэсгийн хуралдааныг 2019.03.21-ны өдөр зохион байгуулж ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлуулав. Хөтөлбөрийн талаар 3 хувилбарт төслийг боловсруулан гишүүдэд танилцуулсан. Эцсийн хувилбарын төслийг сонгон холбогдох журамд заасан судалгаа тооцоог хийж гүйцэтгэсэн. Хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлэгийг 2019.11.14-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт АТҮТ, ЗТХТ, нийслэлийн харъяа агентлагууд, Автотээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцов. Хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл боловсруулан яамдаас санал авахаар 2019.11.19-ны өдрийн 01/6206 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Сангийн яамнаас ирсэн 5-217971 тоот хариу албан бичгэнд Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт”-нд “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” байхгүй тул санал, зөвшөөрөл өгөх боломжгүй байна гэжээ. Иймд тус хөтөлбөрийг 121 дүгээр тогтоолын хавсралтанд нэмж тусгуулах талаар Засгийн газрын гишүүдээс санал авах 01/6634 тоот албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна.	40%	40%
		7.3.6. Тусгай замын автобус системийг (BRT)	Хэрэгжилтийн явц хувиар 50		<b>АТБХЗГ, НЗДТГ:</b> Төслийн удирдах хороо 2018 оны 11 дүгээр сарын 02, 06, 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр тус тус хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:	-	-

			нэвтрүүлэх 1 дүгээр шатны барилгын ажил			<p>1. “Тусгай замын автобусны сүлжээний чиглэл, коридоруудын хэрэгжүүлэх дараалал”-ыг тогтоохдоо:  <u>1 дүгээр үе шатанд</u> буюу Коридор 1А-г Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал, Наадамчдын зам, Яармагийн гүүр, Чингисийн өргөн чөлөө, Сүхбаатарын талбай чиглэлд нийт 14.9 км зам;  <u>2 дугаар үе шатанд</u>: Коридор 1Б-г Сүхбаатарын талбай, Их сургуулийн гудамж, Сүхбаатарын гудамж, Ногоон нуурын гудамж, Алтайн гудамж, Чингэлтэйн өргөн чөлөө, 7-н буудлын автобусны эцсийн зогсоол буюу нийт 7.8 км зам; Коридор 2-г Саппорогийн уулзвар, Ард-Аюушийн өргөн чөлөө, Энэбишийн өргөн чөлөө, Их тойруу, Намьянжугийн гудамж, Их хүрээ гудамж, Дүнжингарав олон улсын худалдааны төвийн уулзвар буюу нийт 10 км замын чиглэл; зэрэг болно.</p> <p>2018, 2019 онуудад төслийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 16 тендерийн материалын төслийг Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн боловч тендер зарлахтай холбоотой хариу ирүүлээгүй.</p> <p>Мөн дээр дурдсанчлан Азийн хөгжлийн банкны зохих зөвшөөрөл хугацаа удсан зэрэг бодит шалтгаан байсан хэдий ч Сангийн сайдын 2019.11.13-ны өдрийн 01/5339 тоот албан бичгээр <b>тус төслийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргаад байгаа</b> бөгөөд НЗДТГ энэхүү байр суурийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, төслийг үргэлжлүүлэх байр сууриа илэрхийлээд байна.</p> <p>Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга нарын 2019.12.13-ны өдрийн албан уулзалтын үеэр Нийслэлийн Засаг дарга тусгай замын автобусны нэвтрүүлэх төслийг цааш дахин үргэлжлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад тавьсан бөгөөд уг төслийг эрчимжүүлэх талаар судлахаа Сангийн сайд илэрхийлсэн.</p>		
4	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.119 дэх заалт	7.4. Замын-Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах	7.4.1. Замын-Үүдийн тээвэр логистикийн төвийг ашиглалтад оруулах;	Барилгын ажлын явц 100	11,480.3 сая төг	<p><b>ТЗДТБХЗГ, Төслийн нэгж:</b>  Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төсөл” нь АХБ-ны хөнгөлөлттэй зээл 40 сая ам.\$, АХБ-ны буцалтгүй тусламж 5 сая ам.\$, МУ-ын ЗГ-ын 26.64 сая ам.\$-ын санхүүжилтийн эх үүсвэртэй.  Барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдрөөс эхлүүлсэн. ЗГ-ын 2018 оны 72 дугаар тогтоолоор гадаадаас ажиллах хүч авахаар шийдвэр гарч тус логистикийн төвийн барилга угсралтын ажлыг</p>	100%	100%

					<p>гүйцэтгэх 230 ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.</p> <p><u>АХБ-ны санхүүжилтээр:</u> Логистикийн төвийн барилга угсралт, төмөр замын дохиолол холбооны ажлыг “Хятадын төмөр замын 21-р товчоо групп” компани;</p> <p><u>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:</u> Авто зам, гүүрэн байгууламж, Хамгаалалтын хашааны, Логистикийн төвийг хангах эрчим хүчний шугам, дэд станцын, Логистикийн төвийг хангах цэвэр усны шугамын барилга угсралтын ажил, Логистикийн төвийн гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах ажил, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ, Логистикийн төвийн зураг төсөлд магадлал хийх ажил, Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсөв боловсруулах ажил, 50 тн даацтай 2 вандан краны нийлүүлэх, угсралт, суурилуултын ажлуудыг “Ийстерн роуд” ХХК, “Ви Эйч энд Би” ХХК, “Катод гал” ХХК, “Хангилцаг” ХХК, “Лийд линк” ХХК, “Монвеком” ХХК, Барилгын хөгжлийн төв, “Баясалтөгс” ХХК, “Багануур Энерги” ХХК, “Хэнань Дафан Хүнд Машин механизм” компани тус тус гүйцэтгэж, 2018.12.04-ний өдрийн байдлаар ажил дууссан.</p> <p>Логистикийн төвийн 50 тн даацтай 2 ширхэг иж бүрэн вандан краны тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд холбогдох журмын дагуу МХЕГ-аас дүгнэлт гаргасан.</p> <p><b>Зам, тээвэр хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Улсын комисс 2018.12.28-31-ний өдрүүдэд ажиллаж, дээрх ажлуудыг 18/432/02 дугаар актаар ашиглалтад хүлээн авсан.</b></p> <p>Тус яамнаас байгуулагдсан ажлын хэсэг 2019.04.10-12-ны өдрүүдэд ажиллан логистикийн төвийн хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж ТӨБЗГ-т хүргүүлсэн. ТӨБЗГ-ын 2019.05.21-ний өдрийн "Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 218 дугаар тогтоол батлагдсан.</p> <p>“Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл”-ийн Замын-Үүд логистикийн төвийн өмчлөгч “Монголын төмөр зам” ТӨХК,</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>ашиглагч “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн хооронд түрээсийн гэрээ байгуулсан.</p> <p>Өмчлөгч болох “МТЗ” ТӨХК 2019.07.16-нд ашиглагч байгууллага болох “УБТЗ” ХНН-тэй “Бүс нутгийн логистикийн төвийг түрээслүүлэх түрээсийн гэрээ”-г байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.</p> <p>ТНБД-ын 2019.02.10-ны өдөр баталсан 376 дугаар тушаалын дагуу Улсын комисс 2019.12.12-13-ны өдрүүдэд ажиллаж, “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдсан 1.184 километр урттай салбар төмөр замыг 10/25/19 дүгээр дүгнэлтээр, 4,3 км хатуу хучилттай авто замыг 10/23/19 дүгээр дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.</p>		
5	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.119 дэх заалт	7.5. Бодит салбарын хөгжлийг дэмжих төмөр замын төслүүдийг үргэлжлүүлэх	7.5.1. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ зураг төслийг боловсруулах	Хэрэгжилтийн явц хувиар 100	<p><b>ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК:</b> Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл нь Монгол-Орос-Хятадын “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн Төмөр замын зүүн коридор байгуулах төсөлд багтсан. “Монголын төмөр зам” ТӨХК нь БНХАУ-ын “Башинь төмөр зам” ХХК-тай санамж бичиг байгуулж, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Башинь төмөр зам” ХХК-ийн санхүүжилтээр Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар хүрээлэнгээр гүйцэтгүүлсэн. <b>Тус ТЭЗҮ үр ашиг багатай гарсан</b> тул Хөөт орчимд нүүрс боловсруулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулж төмөр замтай уялдуулан цогцоор нь хөгжүүлэх, ачааны эх үүсвэрийг нэмэгдүүлж, ТЭЗҮ-г шинэчлэхээр ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2019.09.13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар Хөөт аж үйлдвэрийн парк төсөл санаачлагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ТЭЗҮ, төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Тус ажлын хэсэгт ЗТХЯ-наас холбогдох мэргэжилтэн орж ажиллаж,</p>	-	-

					2019.09.16-ны өдөр ажлын хэсгийн эхний хурал хуралдсан.		
		7.5.2. Улаанбаатар төмөр замын шинэчлэлийн төслийг эхлүүлэх	Хэрэгжилтийн явц хувиар 30		<p><b>ТЗДТБХЗГ, УБТЗ ХНН:</b> “УБТЗ” ХНН-ийн дохиолол, хориглол, төвлөрүүлэлтийн шинэчлэлийн ажлын хүрээнд хэсгийн нэвтрүүлэх чадварыг 20 хос галт тэргээр, тээх чадварыг 33 сая тонн хүртэл нэмэгдүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, ашиглалтын зардлыг бууруулах “Хойд-Улаанбаатар-Замын-Үүд”-ийн чиглэлд нэг замт хоорондын замыг радио сувгаар галт тэрэгний хөдөлгөөнийг хоорондын зай, хугацаагаар зохицуулах системээр тоноглох, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлт, тоон радио холбоо, тоон технологийн холбооны системийг шинэчлэх УБТЗ-ын 65 өртөө, зөрлөгт дохиолол төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгүүлэхээр 2015.10.29-ний өдөр “Элтеза” компанитай гэрээ байгуулж ажилласан ба гэрээний дагуу төслийг 2019.08.30-нд хэрэгжүүлж дууссан. Захиалагч Техникийн комисс ажиллуулсны дараа Улсын комисс хүлээж авах болно.</p>	100%	
		7.5.3. Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх	Хэрэгжилтийн явц хувиар 20		<p><b>ТЗДТБХЗГ, Концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК:</b> Монгол Улсын Засгийн газрын 2017.01.11-ний өдрийн 10 дугаар тогтоолоор “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын шугамын чиг батлагдсан. <b>Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас УИХ-аар “Зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах тухай” тогтоолоор Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангилалаар тусгай хамгаалалтанд авсанаар батлагдсан чигээс 100 гаран км дайран өнгөрсөн, мөн Ханжаргалантын байгалийн нөөц газартай давхцсанаар төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлэх боломжгүй болсон.</b> Ханжаргалантын чиглэлийн төмөр замын чигийн асуудлаар ЗТХС-ын 2018.12.14-ний 293 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2019.06.13-ны өдөр хуралдан трассын дагуу газар дээр нь очиж дүгнэлт гаргах</p>	-	



					үүрэг бүхий ЗТХЯ, БОАЖЯ, ЭХЯ, "Нортерн рэйлвэйс" ХХК, "Эгийн голын УЦС" ТӨХХК нарын хамтарсан Ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсэн. ЗТХС-ын 2019.07.02-ны өдрийн 282 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Булган аймгийн Бугат суманд 2019.07.02-05-ны өдрүүдэд ажиллаж "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замын төслийг Хужирын голын хөндийгөөр зэрэгцүүлэн явуулах боломжийг судалж, батлагдсан чигийн дагуу 47 км газарт Эгийн голын усан цахилгаан станц төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр замын трасстай огтлолцох 6 цэгийг газар дээр нь үзэж Хужирын голын хөндийгөөр явуулах боломжтой гэж үзэн 2019.07.16-ны 19/228/07 дугаартай дүгнэлтийг гаргасан. "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замын Концессын гэрээний хугацаа 2020.04 дүгээр сард дуусахтай холбогдуулан Үндэсний хөгжлийн газраас 2019.08.26-ны өдрийн 01/2255 дугаартай албан бичгээр ажлын хэсэг байгуулах санал ирүүлсэн. Уг саналын дагуу концесс эзэмшигч "Нортерн рэйлвэйс" ХХК-ны захирал н.Ган-Очиртой уулзалт зохион байгуулж Хөвсгөл аймгийн Мөрөн чиглэлээр трассыг өөрчлөх боломжийг судлах, өмнөх шийдвэр, мэдээллийг яамны удирдлагуудад танилцуулах чиглэл өгсөн.			
			7.5.4. "УБТЗ" ХНН-ийн гол замын их засварын ажлыг гүйцэтгэх Их засвар хийгдэх төмөр замын урт, км	50		<b>ТЗДТБХЗГ, УБТЗ ХНН:</b> <u>2019 онд</u> Гол замын их засварын ажлыг хойд, урд чиглэлүүдэд 37 км, Сүхбаатар, Аршаант өртөөдөд 13 км өргөтгөлийн ажил, нийт <b>50 км</b> замд их засварын ажил хийж гүйцэтгээд байна.	100%	100%
6	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114 дэх заалт	6.1. Орон нутгийн нисэх буудлуудын чадавхи дээшлүүлэх	7.6.1. Ховд аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлыг эхлүүлэх	Ажлын явц, хувиар 40		<b>АТБХЗХ, ИНЕГ:</b> Ховд аймгийн нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төслийг "Алтайн газрын хүч" ХХК гүйцэтгэж дуусган ИНЕГ-г хүлээлгэн өгсөн. Зураг төслийг экспертизээр батлуулах шатанд байна. Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд	-	-

					<p><b>санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна.</b>  2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Ховд аймгийн нисэх буудлын аэродромын өргөтгөлийн ажилд 28 тэрбум төгрөг 2020 оны улсын төсөвт тусгуулахаар санал өгсөн.</p>		
		7.6.2. Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлыг эхлүүлэх	Ажлын явц, хувиар 40		<p><b>АТБХЗХ, ИНЕГ:</b> Өмнөговь аймгийн “Гурвансайхан” нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийн зураг төсвийг гүйцэтгүүлэхээр “Алтайн газрын хүч” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. Зураг төсөв боловсруулах ажил 85%-тай байна.  Нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох Зам,тээврийн хөгжлийн сайдын 2017.07.04-ний өдрийн 137, 2017.10.13-ны 209 дүгээр тушаалаар батлуулсан “ИНЕГ-ын 2011, 2013, 2015, 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тус нисэх буудлыг 4D ангиллын нисэх буудал болгох, өртгөтгөх зураг, төсөв боловсруулахад 300.0 сая төгрөгийг тусгасан.  ИНЕГ болон “ЭЗТ” ХХК хооронд “Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадал бүхий нисэх буудал болгох, өргөтгөх зураг, төсөл боловсруулах” ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-09/19 дүгээр гэрээг 2019.10.25-ны өдөр байгуулсан. Зураг төсөл боловсруулах ажлын явц 40%-тай байна.  Нисэх буудлыг өргөтгөн шинэчилэх ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд <b>санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна.</b>  2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж</p>	-	

					санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.		
			8.3.1.Улаанбаатар хот болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурин, хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх	Боловсруулах ерөнхий төлөвлөгөөний тоо10	<p><b>БТГ:</b> Баруун бүсийн тулгуур төв Завхан аймгийн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд зам, тээврийн салбарын нийт 12 арга хэмжээний саналыг 2019-04-23-ны өдрийн 03/1991 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Алтанбулаг, Замын-Үүд боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцон уг боомтуудад холбоотой зам, тээврийн төсөл, хөтөлбөрийн талаар танилцуулга хийсэн. Мөн Ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа төслийн багынхантай уулзалт зохион байгуулан шаардлагатай мэдээллээр ханган ажилласан. Уг ерөнхий төлөвлөгөөний төсөл, тайланг БХБЯ-ны ШУТЗ болон СЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.</p> <p>Сүхбаатар аймгийн Бичигт хилийн боомтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамнаас хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 03/2764 тоот албан бичгээр БХБЯ-д хүргүүлсэн. Мөн Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нэмэлтээр тусгуулахаар зам, тээврийн салбарт хэрэгжих төслүүдийн мэдээлэл, Бичигт боомтод логистикийн төв байгуулах саналыг 2019 оны 09 дүгээр сарын 20-ны 04/5008 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлээд байна.</p> <p>Улаанбаатар хотын шинэ нисэх буудлыг даган хөгжих Аэро сити шинэ хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголд Богдхан төмөр зам, АН-3 хурдны авто зам, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулахаар төслүүдийн мэдээллийг БХБЯ-д нууцын бичгээр хүргүүлсэн. Уг төслүүд Аэро сити дагуул хотын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд шинэ хот /аэросити/-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг</p>	40%	40%

					<p>Засгийн газрын 2019 оны нэгдүгээр сарын 16-ны 29 дүгээр тогтоолоор баталсан.</p> <p>Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын хоёрдугаар хуралдааны протоколын хэрэгжилт, гуравдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудалд зам, тээврийн салбараас тусгах асуудлыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын гуравдугаар хуралдаан 2019 оны 9 дүгээр сарын 9-10 өдөр зохион байгуулахад зам, тээврийн яамны холбогдох албан хаагчид оролцон зам, тээврийн салбарын бодлогын хүрээнд хилийн боомтуудтай холбоотой асуудлуудыг шийдвэрлүүлэхээр тулгарч байгаа хүндрэл, шийдвэрлүүлэх асуудлаа танилцуулсан. Мөн гуравдугаар хуралдааны протоколыг хэрэгжилтийг хангах төлөвлөгөөний төсөлд 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03/4352 тоот албан бичгээр санал хүргүүлсэн.</p>		
			<p>9.6.1.Аялал жуулчлалын чиглэлийн үйлчилгээний цогцолборыг байгуулах гол дагуу</p>	<p>Үйлчилгээний цогцолбор байгуулах ажлын явц, /хувиар/50</p>	<p><b>АТБХЗГ, АЗБХЗГ:</b></p> <p>ЗТХ-ийн сайд, аймгийн Засаг даргатай зам, тээврийн салбарт 2018 онд хамтран ажиллах гэрээнд автотээврийн салбарт шаардлагатай байгаа автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих-өмчлөх-ашиглах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллах заалтыг тусгасан. Улсын төсвийн хөрөнгө, "АТҮТ" ТӨҮГ-ын хөрөнгөөр дараах аймаг, сумдад автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолбор барь ашиглалтад оруулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд автобуудлын барилгын өргөтгөл;</li> <li>2. Хэнтий аймагт автобуудал;</li> <li>3. Архангай аймгийн Цэцэрлэг суманд автобуудал;</li> <li>4. Дорноговь аймгийн Сайншанд суманд автобуудал;</li> <li>5. Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт улсын чанартай авто замын дагуу "Урьхан-2" үйлчилгээний цогцолбор;</li> <li>6. Баян-Чандмань сумын нутаг дэвсгэрт Аглагийн хийд рүү эргэдэг уулзварын үйлчилгээний цогцолбор;</li> <li>7. Төв аймагт улсын төсвийн хөрөнгөөр автобуудал;</li> <li>8. Завхан аймгийн Улиастай суманд автобуудал;</li> </ol>	100%	100%

					<p>9. Баянхонгор аймгийн Баянхонгор суманд автобуудал барьж үйл ажиллагаа эхлүүлсэн.</p> <p>10. Увс аймгийн Улаангом сумын Цагаан дэглий нисэх буудлын барилгыг автобуудал болгон өөрчлөн тохижуулсан.</p> <p>11. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвд Худалдааны төвийн барилгыг автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн зориулалтаар ашиглах асуудлыг ЗГ, УИХ-аар шийдвэр гаргуулж, “АТҮТ” ТӨҮГ хүлээж авсан.</p> <p>12. Сэлэнгэ аймагт дахь “УБТЗ” ХНН-ийн автобуудлаас улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэх шийдвэр гаргуулж, үйл ажиллагаа эхлүүлсэн.</p> <p>13. Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэр “Элсэн тасархай”-т “Сод хан трэвел” ХХК, Багануур дүүрэг "Минимакс", Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт "Бумбат цоцолбор" зэрэг улсын чанартай авто зам дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд авто замын дагуу үйлчилгээний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.</p> <p>Улаанбаатар хот, Ховд, Дорнод зэрэг аймгуудад шаардлагатай автобуудал, авто замын дагуу үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг орон нутгийн концессын зүйлийн жагсаалтад оруулж, сонирхогч аж ахуйн нэгжээр барих-өмчлөх-ашиглах төрлөөр хэрэгжүүлэхээр аймаг, нийслэлийн ИТХТ-ийн шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.</p>		
НИЙТ					91.6%	88.46%	

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ